

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2018 оны 9 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү хамтын ажиллагааны санамж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг нэг талаас Монголбанк /цаашид “МБ” гэх/, нөгөө талаас Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт /цаашид “ММНБИ” гэх/дор дурдсан асуудлаар харилцан тохиролцон үйлдэв.
- 1.2 Хамтын ажиллагааны санамж бичгийн зорилго нь МБ, ММНБИ (цаашид “талууд” гэх) “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үндэсний хэмжээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх, жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчдийн бүртгэл, тайлагналын чанарыг сайжруулах, салбарын мэргэжилтний чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамтран оролцох, хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлэхэд оршино.
- 1.3 Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан Төв банкны /Монголбанк/-ны тухай хууль, Боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ММНБИ-ийн дүрэм, Монгол Улсын бусад хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгоно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.

- 2.1 Хөтөлбөрийн хүрээнд үндэсний хэмжээнд сургагч багш нарыг бэлтгэх, тэднийг чадавхжуулах; хамтарсан эрдэм шинжилгээ, олон талт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг тус тусын цахим хуудсанд байршуулж, тогтмол шинэчилж байх;
- 2.2 Санхүүгийн мэдлэг олгох гарын авлага, багшийн ном, орон нутгийн иргэдэд сургалт явуулахад ашиглагдах материал, видео хичээл болон бусад цаг үеийн хэрэглэгдэхүүн боловсруулах;
- 2.3 Санхүүгийн боловсролын чиглэлээр туршлага судлах дотоодын болон олон улсын сургалтад хамрагдах;

- 2.4 Хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд аж ахуйн нэгжүүд, бичил бизнес эрхлэгчдийг санхүүгийн тайлан гаргах арга зүйг эзэмшүүлэх, тэдний нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг стандартад нийцүүлэх;
- 2.5 Арилжааны банк болон мэргэжлийн оролцогчдын бүртгэл, тайлагналын гарын авлага, стандартын хэрэглээний тайлбар, арга аргачлал боловсруулах;
- 2.6 Банкны системд ажиллаж буй нягтлан бодогчдын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэх зорилгоор мэргэшүүлэх зорилгоор мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон захиалгат сургалтуудыг зохион байгуулах;
- 2.7 Банкны санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой олон улсын стандартыг орчуулж, нэвтрүүлэхэд хамтран ажиллах;
- 2.8 Банкны нягтлан бодогч, аудиторын баримтлах стандарт, дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд Монголбанкнаас санал, мэдээлэл авч байх.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 3.1 Талууд энэхүү санамж бичигт заасан үүргийг биелүүлж, бүрэн хариуцлага хүлээн ажиллана.
- 3.2 Талууд энэхүү санамж бичгээр харилцан тохиролцоогүй болон нарийвчилсан ажилд хамтран ажиллах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулж болно.
- 3.3 Хамтран гүйцэтгэх ажил үүргийг талууд тухайн тохиолдолд нарийвчлан тохиролцох бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд талуудын хоорондын харилцаанд энэхүү санамж бичгийг баримтална.
- 3.4 Энэхүү санамж бичгийн хугацаа дуусахад түүнийг сунгах буюу дахин шинээр байгуулж болно.
- 3.5 Энэхүү санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд санамж бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд 3 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2018 оны 9 дүгээр сарын 27 -ны өдөр монгол хэлээр хоёр хувь үйлдэв.

